

**“ЛЮКС ЗАНАДУ ГРУПП” ХК  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ**

2021 оны 8-р сарын 17 өдөр

Дугаар: 20/01/ 07

Улаанбаатар хот

**КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ДАРГЫГ СОНГОХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 78-р зүйлийн 78.1, дэх заалтыг үндэслэн **ТОГТООХ**  
**НЬ:**

1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн анхдугаар хуралд оролцсон нийт 9 гишүүний 100 хувийн саналаар Б.Насан-Эрдэнийг ТУЗ-ийн даргаар сонгосугай.
2. Компанийн тухай хууль, компанийн дүрэм, журмаар тогтоосон үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ТУЗ-ийг удирдан зохион байгуулж ажиллахыг Б.Насан-Эрдэнэд үүрэг болгосугай.

**ТУЗ-ИЙН ГИШҮҮД :**

1. А.Хадбаатар
2. Б.Болорцэцэг
3. С.Отгонбилэг
4. Б.Насан-Эрдэнэ
5. Б.Одмаа
6. Э.Болор-Эрдэнэ
7. Б.Сугарсүрэн
8. Г.Мөнхбаяр
9. О.Нандинчимэг



*Хадбаатар*  
.....  
*Б. Болорцэцэг*  
.....  
*С. Отгонбилэг*  
.....  
*Насан-Эрдэнэ*  
.....  
*Б. Одмаа*  
.....  
*Э. Болор-Эрдэнэ*  
.....  
*Б. Сугарсүрэн*  
.....  
*Г. Мөнхбаяр*  
.....  
*О. Нандинчимэг*  
.....

**“ЛЮКС ЗАНАДУ ГРУПП” ХК  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ**

2021 оны 8-р сарын 17 өдөр

Дугаар: 20/01/08

Улаанбаатар хот

**КОМПАНИЙН ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГЫГ ТОМИЛОХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 76-р зүйлийн 76.1.8. дах заалт, ТУЗ-ийн даргаас оруулсан саналыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. ТУЗ-ийн анхдугаар хуралд оролцсон нийт 9 гишүүний 100 хувийн саналаар Жигмэддагва овогтой Үүрийнтуяаг компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар томилсугай.
2. Компанийн тухай хууль, компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан нарийн бичгийн даргын эрх үүргийг үндэслэн Ж. Үүрийнтуяатай байгуулах ажил гүйцэтгэх гэрээг хавсралтаар баталсугай.
3. ТУЗ-ийг төлөөлөн гэрээнд гарын үсэг зурахыг ТУЗ-ийн дарга Б. Насан-Эрдэнэд зөвшөөрсүгэй.
4. Компанийн тухай хууль, компанийн дүрэм болон ажил гүйцэтгэх гэрээнд заасан чиг үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ажиллахыг Ж. Үүрийнтуяад үүрэг болгосугай.

**ТУЗ-ИЙН ДАРГА**



**Б.НАСАН-ЭРДЭНЭ**

**“ЛЮКС ЗАНАДУ ГРУПП” ХК**  
**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН**  
**ТОГТООЛ**

2021 оны 8-р сарын 17 өдөр

Дугаар: 20/01/ 09

Улаанбаатар хот

**ТУЗ-ИЙН ХОРООДЫГ БАЙГУУЛАХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 81-р зүйлийн 81.2. дах заалт, ТУЗ-ийн гишүүдийн саналыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. ТУЗ-ийн Аудитын хорооны гишүүдээр дараах нэр бүхий гурван гишүүнийг сонгосугай.
  1. Б.Болорцэцэг /Дарга/
  2. О.Нандинчимэг
  3. Г.Мөнхбаяр
2. ТУЗ-ийн Нэр дэвшүүлэх хорооны гишүүдээр дараах нэр бүхий гурван гишүүнийг сонгосугай.
  1. Э.Болор-Эрдэнэ /Дарга/
  2. О.Нандинчимэг
  3. С.Отгонбилэг
3. ТУЗ-ийн Цалин урамшууллын хорооны гишүүдээр дараах нэр бүхий гурван гишүүнийг сонгосугай.
  1. Э.Хадбаатар /Дарга/
  2. С.Отгонбилэг
  3. Г.Мөнхбаяр
4. Компанийн тухай хууль, компанийн дүрэм, Хороодын үйл ажиллагааны журмаар тогтоосон үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ажиллахыг Хорооны дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Б.НАСАН-ЭРДЭНЭ

**“ЛЮКС ЗАНАДУ ГРУПП” ХК  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ**

2021 оны 8-р сарын 17 өдөр

Дугаар: 20/01/ 10

Улаанбаатар хот

**КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫГ СОНГОХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 76-р зүйлийн 76.1.8. дах заалт, ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хорооноос оруулсан саналыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. ТУЗ-ийн хуралд оролцсон 9 гишүүний 100 хувийн саналаар Баянмөнх овогтой Сугарсүрэнг компанийн гүйцэтгэх захирлаар сонгосугай.

2. Компанийн тухай хууль, компанийн дүрэмд нийцүүлэн гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээг хавсралтаар баталж, уг гэрээнд ТУЗ-ийг төлөөлөн гарын үсэг зурахыг ТУЗ-ийн дарга Б.Насан-Эрдэнэд зөвшөөрсүгэй.

3. Компанийн тухай хууль, компанийн дүрэм, хөлсөөр ажиллах гэрээнд заасан чиг үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ажиллахыг Б.Сугарсүрэнд үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА *Насан - Эрдэнэ* Б.НАСАН-ЭРДЭНЭ

